



ЭРҮҮЛ МЭНДИЙН САЛБАРЫН
УДИРДАХ АЖИЛТНЫ ЗӨВЛӨГӨӨН
2022

Эрүүл мэндийн байгууллагуудын 2021 оны гүйцэтгэлийн үнэлгээний дүн, ЗӨВЛӨМЖ

С.Төгсдэлгэр, ХШҮДАГ-ын дарга

Гүйцэтгэлийн хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго

- Гүйцэтгэл – эрүүл мэндийн байгууллага/тогтолцоо үндсэн зорилгоо хэрэгжүүлж байгаа байдал
- ЭМБайгууллага /тогтолцооны үндсэн зорилго:
 - Үйлчлүүлэгч/хүн амын эрүүл мэндийг сайжруулах
 - Үйлчлүүлэгч/хүн амын сэтгэл ханамж, хүлээлтийг хангах
 - Үйлчлүүлэгч/хүн амыг санхүүгийн эрсдлээс хамгаалах
 - Тусламж үйлчилгээний үр ашгийг нэмэгдүүлэх

Гүйцэтгэлийн хяналт-шинжилгээ, үнэлгээний хамрах хүрээ

Байгууллагын амжилтын Куинны загвар

Дотоод орчин	Баг, хамт олон Хамтын ажиллагаа, оролцоо, хүний хөгжил	Ажлын үр дүн Бүтээгдэхүүн, инноваци, дасан зохицох чадвар	Гадаад орчин
	Ажлын зохион байгуулалт Үр дүнтэй, саадгүй, шуурхай үйл ажиллагаа, явцын хяналт	Зах зээл Хэрэглэгчийн сэтгэл ханамж, өрсөлдөх чадвар, ашигтай ажиллагаа	

Гүйцэтгэлийн хяналт-шинжилгээ, үнэлгээний хамрах хүрээ

ЭМСайдын 2021 оны 605 дугаар тушаал

Дотоод орчин	3.1.1.2 ТАХ-ийн нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн биелэлт	3.1.1.4 ЭМТҮ-ний чанарын үзүүлэлтийн биелэлт	Гадаад орчин
	3.1.1.3.2 Хүний нөөцийн ил тод байдал		
	3.1.1.1 Гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт	3.1.1.5 Хэрэглэгчийн үнэлгээ	
	3.1.1.3.1 Үйл ажиллагааны ил тод байдал	3.1.1.3.3 Шилэн дансны хөтлөлт	

ХШҮ-ний аргачлал (эрх зүйн үндэслэл)

1. Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд ХШҮ хийх нийтлэг журам (ЗГ-ын 2020 оны 206 дугаар тогтоол)
2. Аргачлал, загвар батлах тухай (ЗГХЭГ-ын даргын 2020 оны 100 дугаар тушаал)
3. ЭМБ-ын үйл ажиллагаанд ХШҮ хийх нийтлэг журам (ЭМСайдын 2021 оны А/605 дугаар тушаал)
4. ЭМСалбараар үйлчлүүлж буй хэрэглэгчийн сэтгэл ханамжийн үнэлгээ хийх журам (ЭМСайдын 2021 оны А/578 дугаар тушаал)

ХШҮ-ний аргачлал (мэдээний эх сурвалж)

1. ЭМБайгууллагаас ирүүлсэн тайлан
2. ЭМЯ-ны газар, хэлтсээс гаргасан мэдээ, мэдээлэл
3. ЭМХТ-өөс ирүүлсэн статистик тоо мэдээ, хэрэглэгчийн үнэлгээний тайлан
4. Аймаг, нийслэлийн Засаг даргаас ЭМГ-ын үйл ажиллагааны гүйцэтгэлийг дүгнэсэн үнэлгээ
5. ЭМБайгууллагуудын Шилэн данс, цахим хуудас

ХШҮ-ний аргачлал (дүгнэх арга)

Хүснэгт 3.9.

Үзүүлэлт		Хувь	Жин	Оноо
1	2	3	4	5
Байгууллагын чиг үүргийн үзүүлэлтийн үнэлгээ	1. Байгууллагын тухайн жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт		0.2	
	2. Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн биелэлт		0.15	
	3. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанарын үзүүлэлтийн биелэлт		0.3	
Байгууллагын нээлттэй байдлын үнэлгээ	4. Байгууллагын ил тод байдал	Үйл ажиллагааны ил тод байдал		
		Хүний нөөцийн ил тод байдал		
		Шилэн дансны хөтлөлт		
	5. Хэрэглэгчийн үнэлгээ		0.2	
Ерөнхий үнэлгээ:			1.0	

ХШҮ-ний дүн, анхаарах асуудал (2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт)

1. Дундаж – 88.6% (“тодорхой үр дүнд хүрсэн”)
2. Анхаарах асуудал:
 - a. Зарим байгууллага гүйцэтгэлийн төлөвлөгөө батлуулаагүй
 - b. Төлөвлөлт байгууллагын үндсэн чиг үүрэг, бодлогын баримт бичгүүдтэй уялдаагүй
 - c. Тайлагналт оновчгүй (журмын 6.8: тухайн арга хэмжээний гүйцэтгэл, үр дүнг 2000 тэмдэгтэд багтаан тайлагнана)
 - d. Хугацаа хоцроосон (журмын 10 дугаар зүйлийн дагуу хариуцлага тооцох үндэслэл)
 - e. Журмын 6.9-ийн дагуу төлөвлөгөөний биелэлтэд ХШҮ хийж, дүнг УЗ-ийн хурлаар хэлэлцүүлж, шийдвэрийг 34 байгууллага ирүүлээгүй (журмын 10 дугаар зүйлийн дагуу хариуцлага тооцох үндэслэл)

ХШҮ-ний дүн, анхаарах асуудал

(ТАХ-ийн нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн биелэлт)

1. Дундаж – 68.8% (“эрчимжүүлэх шаардлагатай”)
2. Анхаарах асуудал:
 - a. Журмын дагуу тайлагнасан: Архангай, Говьсүмбэр, Дорноговь, Дундговь ЭМГ, УГТЭ
 - b. ТАХ-ийн нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн зорилтот түвшинг тодорхойлоогүй 12 байгууллага
 - c. ТАХ-ийн нийгмийн баталгааг хангахад зарцуулсан зардал улсын төсвөөс олгодог мөнгөн тэтгэмж, илүү цагийн хөлс, хоол унааны мөнгөөр хязгаарлагдаж байна
 - d. Тайлагнасан тоо мэдээний үнэн бодитой байдал эргэлзээтэй
 - e. Албан хаагчдын шилжилт хөдөлгөөний хувийг 23 байгууллага тайлагнаагүй

ХШҮ-ний дүн, анхаарах асуудал (байгууллагын ил тод байдал)


1. Дундаж – 64.8% (“эрчимжүүлэх шаардлагатай”)
 - Үйл ажиллагааны ил тод байдал
 - Хүний нөөцийн ил тод байдал
 - Шилэн дансны хөтлөлт
2. Анхаарах асуудал:
 - а. Шилэн дансны мэдээллийг хугацаа хоцроож мэдээлэх
 - б. Шилэн дансны тайланг улирал бүр ЭМЯ-нд цахимаар ирүүлж хэвшээгүй
 - в. Албан ёсны цахим хуудсыг тогтмол ажиллуулж, мэдээлэл шинэчлэх нь хангалтгүй

ХШҮ-ний дүн, анхаарах асуудал

(хэрэглэгчийн үнэлгээ)

1. Дундаж – 80.5% (“сайн”)
2. Анхаарах асуудал:
 - a. ЭМХТ-өөс 17 байгууллагад хийсэн, бусад нь – өөрийн үнэлгээ
 - b. ЭМХТ-өөс жил бүр улсын хэмжээнд хэрэглэгчийн сэтгэл ханамжийн үнэлгээг зохион байгуулах, шаардлагатай зардлыг жил бүр төсөвтөө тусган батлуулах (ЭМСадын 2021 оны 578 дугаар тушаал)
 - c. Хэрэглэгчийн үнэлгээг хөндлөнгийн байгууллагаар гүйцэтгүүлэх
 - d. Хэрэглэгчийн үнэлгээг цахим хэлбэрээр авах боломжийг бүрдүүлэх

2021 онд иргэдээс ЭМЯ-нд гаргасан гомдлын тоо



ХШҮ-ний дүн, анхаарах асуудал (тусламж үйлчилгээний чанарын үзүүлэлт)

1. Дундаж – 83.1% (“сайн”)
2. Анхаарах асуудал:
 - a. Эхийн эндэгдлийн түвшин 2.7 дахин нэмэгдсэн
 - b. Нялхас, 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл, амьгүй төрөлт өмнөх оны түвшинд
 - c. НҮ-н насны 1000 эмэгтэйд ногдох үр хөндөлтийн түвшин өмнөх оны түвшинд
 - d. Төрөлхийн тэмбүүгийн тохиолдлын тоо 2 дахин буурсан
 - e. ЧШ-ийн эрт илрүүлэлт өмнөх оноос нэмэгдсэн
 - f. АД ихсэх өвчний эрт илрүүлэлт өмнөх оноос нэмэгдсэн ч хангалтгүй хэвээр
 - g. Хорт хавдрын эрт илрүүлэлт өмнөх оноос буурсан
 - h. Сэргийлж болох нас баралтын түвшин нэмэгдсэн

Үнэлгээний нэгдсэн дүнгээр салбарын хэмжээнд эрүүл мэндийн байгууллагуудын 2021 оны үйл ажиллагааны гүйцэтгэлийн үнэлгээ

76.2% буюу “тодорхой үр дүнд хүрсэн” гэж үнэлэгдэв.

Энэхүү үнэлгээ нь зорилт нь шалгуур үзүүлэлт болон зорилтот түвшиндээ бүрэн хүрээгүй, хэрэгжилт үр дүнг нэмэгдүүлэх шаардлагатай гэсэн үг юм.

Эрүүл мэндийн яамны түвшинд

- Эрүүл мэндийн яамны харьяа байгууллага, Төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, тусгай мэргэжлийн төв, Аймаг нийслэлийн эрүүл мэндийн газар, Бүсийн оношлогоо эмчилгээний төвийн “Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө”-г Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2020 оны 100 дугаар тушаалын 3 дугаар хавсралтын дагуу боловсруулж, тухайн жилийн 1-р улиралд багтаан баталгаажуулж байх
- Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулахдаа тавигдах нийтлэг болон тусгай шаардлагыг хангасан эсэхэд ТЗУГ хяналт тавих
- Төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, тусгай мэргэжлийн төвүүдийн 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд бодлогын баримт бичигтэй уялдуулан, зорилт, шалгуур үзүүлэлтийг зөв тодорхойлж, зорилтот түвшинг бодитой томьёолон, гүйцэтгэл, үр дүнг тооцон оруулах

Эрүүл мэндийн байгууллагуудын түвшинд

- Стратеги төлөвлөгөөнд тусгасан зорилтын хүрээнд хүлээгдэж байгаа өөрчлөлтийг илэрхийлсэн тодорхой зорилт, арга хэмжээг агуулсан байх бөгөөд зорилт, арга хэмжээ нь хоорондоо уялдсан байх
- Төлөвлөгөөнд зорилт, арга хэмжээг хэрэгжүүлснээр бий болох үр дүн, түүнийг хэмжих шалгуур үзүүлэлтийг тодорхойлсон байх
- Шалгуур үзүүлэлтийн хүрэх түвшин нь тухайн жилдээ хэрэгжих боломжтой, тоон ба чанарын утгаар илэрхийлэгдэх, хэмжигдэхүйц, үр дүнг харуулсан байх бөгөөд бодлогын баримт бичиг, статистик тоон мэдээлэл, салбарын мэдээлэлд үндэслэсэн байх
- Тайлант жилд тухайн асуудлын хүрээнд гарсан өөрчлөлтийг (ахиц, дэвшил, бууралт) тодорхой гаргахын тулд тоон үзүүлэлттэй, харьцуулалт хийх зарчмаар тайлагнах
- Байгууллага бүр гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, үнэлгээний танилцуулга, дүнг байгууллагын удирдлагын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн, хурлаас гарсан дүгнэлт, зөвлөмжийг иж бүрэн тайлан, хэрэгжилтийн хамт албан бичгээр Эрүүл мэндийн яаманд ирүүлж байх

Эрүүл мэндийн байгууллагуудын түвшинд

- Албан хаагчдын шилжилт хөдөлгөөний хувийг заавал тайлагнах
- Эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгийг жилд 1-ээс дээш удаа зохион байгуулах
- Албан хаагчдын нийгмийн хамгааллыг сайжруулахад орон нутгийн засаг захиргааны оролцоог нэмэгдүүлэхэд анхаарах
- Дутуу хэрэгжүүлсэн, огт хэрэгжүүлээгүй үйл ажиллагааг тайлагнахгүй өнгөрөх, хүснэгтээс хасах гэх мэт зохисгүй үйлдэл гаргахгүй байхад анхаарах
- 2022.05.01-ээс хэрэгжиж эхлэх Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийг хэрэгжүүлэх бэлэн байдлыг хангах
- Байгууллагын цахим хуудсанд хүний нөөцийн ил тод байдлын мэдээллийг бүрэн байршуулах
- Эрүүл мэндийн байгууллагууд цахим хуудас тогтмол ажиллуулж, мэдээ мэдээллийг байнга шинэчилж байх
- Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангах (тогтоосон хугацаанд мэдээ мэдээллийг тогтмол, шуурхай мэдээлж хуулийн хугацаанд үнэн зөв байршуулах)